

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих.
Ерөнхий шаардлага**

MNS 5012:2021

Албан хэвлэл

**Стандарт, хэмжил зүйн газар
Улаанбаатар хот
2021 он**



Өмнөх үг

Стандартчилал, хэмжил зүйн газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үндэсний стандартын төсөл боловсруулах ажлыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2021, MNS 1-2:2006 стандартын дагуу төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус Газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг дахин хянах ажлыг Нийслэлийн нийтийн тээврийн газрын саналыг үндэслэн 2021 оны ТХ15/Тээврийн стандартчиллын хөтөлбөрт тусгасны дагуу Нийслэлийн нийтийн тээврийн газрын Тээврийн төлөвлөлтийн хэлтсээс боловсруулсан болно.

Энэ стандартыг 2011 оны ТХ15/Тээврийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжсэн болно.

Энэ стандартын 8.4, 10.8 дахь заалтыг Стандарт, хэмжил зүйн даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн С/5 дугаар тушаал, 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн С/5 дугаар тушаалаар тус тус түр түдгэлзүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн С/45 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсныг стандартад тусгаж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энх тайваны өргөн чөлөө 46А

Шуудангийн хаяг

Улаанбаатар-13343, Ш/Х - 48

Утас: 976-51-263860, 51-266754, Факс: 976-11-458032

Е-mail: standardinform@masm.gov.mn

www.estandard.gov.mn

© СХЗГ, 2021

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 43.020

Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага	MNS 5012:2021
Public transport. Classification and General requirements for services	MNS 5012:2011-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн С/65 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэхүү стандартын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах нийтлэг шаардлагыг тогтоох, төрийн байгууллагаас тухайн үйлчилгээнд тавих хяналт, ажил үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 Хамрах хүрээ

2.1. Энэхүү стандарт нь нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон үйлчилгээнд тавих шаардлагыг тодорхойлоход хамаарна.

2.2. Уг стандартыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, үйлчилгээнд хяналт тавих эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

3 Норматив эшлэл

Энэхүү стандартад эш татсан стандарт, баримт бичгүүдийн хамгийн сүүлийн баталсан хэвлэл (нэмэлт, өөрчлөлтийн хамт)–ийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1** MNS 4598, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих техникийн ерөнхий шаардлага;
- 3.2** MNS 4599, Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлт;
- 3.3** MNS 4601, Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт;
- 3.4** MNS 5025, Авто үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага;
- 3.5** MNS 5537, Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж. Үндсэн шаардлага;
- 3.6** MNS 5342, Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага;
- 3.7** MNS 5347, Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал ба ерөнхий шаардлага;
- 3.8** MNS 5831, Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага;
- 3.9** MNS 5879, Нийтийн тээвэр. Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага;
- 3.10** MNS 6225, Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA- 800F загварын Дубус. Техникийн ерөнхий шаардлага;



MNS 5012:2021

3.11 MNS 5773, Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл. JEA-800 загварын троллейбус угсрах, ашиглах. Үндсэн параметр ба техникийн ерөнхий шаардлага;

3.12 MNS ISO 45001, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо. Шаардлага;

3.13 MNS 6593, Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэлт.

4 Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандартад хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгож, хэрэглэнэ.

Үүнд:

4.1

Нийтийн тээвэр

эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтийн үйлчилгээний замын чиглэл, цагийн хуваарийн дагуу болон зохион байгуулалттай гүйцэтгэж байгаа зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ

4.2

Нийтийн тээврийн үйлчилгээ

Нийтийн тээврийн хэрэгслээр тав тухтай, соёлтой, шуурхай, аюулгүй үйлчлүүлэх иргэдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа.

4.3

Нийтийн тээврийн хэрэгсэл

Зорчигч тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автобус, такси, цахилгаан тээврийн хэрэгсэл

4.4

Зорчигч

нийтийн тээврийн хэрэгслээр зорчих тийз, тасалбарыг цахимаар болон бусад хэлбэрээр худалдан авсан хүн

4.5

Зорчигч тээвэрлэлт

Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчийг нэг цэгээс нөгөө цэгт хүргэх ажил, үйлчилгээ

4.6

Зорчигч тээвэрлэлтийн төлөвлөлт

Зорчигч тээвэрлэлтийн төлөвлөлт гэж зорчигчийг нэг цэгээс нөгөө цэгт хүргэхтэй холбогдсон цаашдын бодлого, зорилго, хөрөнгө оруулалт, орон зайн төлөвлөлтийн загварыг тодорхойлох үйл явц

4.7

Улс хоорондын зорчигч тээвэрлэлт

Монгол Улсын хилийг нэвтрэн хийх зорчигч тээвэрлэлт

4.8

Хот хоорондын зорчигч тээвэрлэлт

Хот, аймгуудын нутаг дэвсгэрийг дамжин хийх зорчигч тээвэрлэлт



4.9**Орон нутгийн зорчигч тээвэрлэлт**

Тухайн аймаг, сумдын нутаг дэвсгэрт хийх зорчигч тээвэрлэлт

4.10**Хотын доторх ба хот орчим, аймгийн төвийн доторх зорчигч тээвэрлэлт**

Тухайн хотын болон түүний дагуул дүүрэг, аймгийн төвийн нутаг дэвсгэрийн хүрээнд гүйцэтгэх зорчигч тээвэрлэлт

4.11**Тээвэрлэгч**

Эрх бүхий байгууллагатай нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага

4.12**Замнал**

зорчигч тээвэрлэх чиглэлийн эхний ба эцсийн зогсоолуудын хооронд батлагдсан зам

4.13**Хөдөлгөөний цагийн хуваарь**

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн хөдөлгөөний дэглэмийг тогтоосон баримт бичиг.

4.14**Замналын зураглал**

Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн батлагдсан замналын дагуу явах хөдөлгөөний зураг.

4.15**Нийтийн тээврийн жолооч**

Нийтийн тээврийн хэрэгслийг жолоодох зохих ангиллын жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй, нийтийн тээврийн хэрэгслийн жолоочоор ажиллаж байгаа хүн.

4.16**Нийтийн тээврийн кондуктор**

нийтийн тээврийн кондукторын мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа хүн

4.17**Нийтийн тээврийн шалгагч**

нийтийн тээврийн хэрэгслийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавих, цахим төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, зорчигчдыг аюулгүй, тав тухтай орчинд зорчих нөхцөл бүрдсэн эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийх, зөрчлийг илрүүлэх, баримтжуулах, холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдэгдэж зөрчлийг арилгуулах, зөрчлийн тоон мэдээ тайлан гаргах, цахим төлбөрийн хэрэгсэл худалдах, цэнэглэх эрх бүхий этгээд

4.18**Тээвэр зохицуулагч**

Нийтийн тээврийн үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг



MNS 5012:2021

хангах, хяналт тавих, шаардлагатай тохиолдолд түргэн шуурхай арга хэмжээ авч асуудлыг зохицуулах хүн

4.19

Зорчигч урсгал

Нийтийн тээврийн үйлчилгээнд нэгж хугацаанд тээсэн зорчигчдын тоо

4.20

Захиалгат үйлчилгээ

Тодорхой орон зай, цаг хугацаанд олон нийтийг хамарсан, зохион байгуулалттайгаар гүйцэтгэх тогтмол бус зорчигч тээвэрлэлт.

4.21

Удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн систем

Нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн бүртгэл хяналт хийх, иргэдэд мэдээлэл өгөх, төлбөрийн нэгдсэн систем бүхий цогц үйл ажиллагаа.

5 Нийтийн тээврийн үйлчилгээний ангилал

Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгэх нутаг дэвсгэрийн хүрээнээс хамааруулж дараах байдлаар ангилна. Үүнд:

5.1 Улс хоорондын зорчигч тээвэрлэлт,

5.2 Хот хоорондын зорчигч тээвэрлэлт

5.3 Орон нутгийн зорчигч тээвэрлэлт,

5.4 Хотын доторх ба хот орчим, аймгийн төвийн доторх зорчигч тээвэр

Хотын доторх ба хот орчим, аймгийн төвийн доторх нийтийн тээврийн үйлчилгээ нь хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, зорчигч урсгалын хэмжээ болон хөдөлгөөний дэглэмээс хамаарч дараах төрөл байна. Үүнд:

5.4.1 Ердийн

5.4.2 Буухиа (экспресс)

5.5 Хөдөлгөөний ердийн дэглэмийн үед нийтийн тээврийн хэрэгсэл нь замналын дагуух бүх зогсоолд зогсоно.

5.6 Хөдөлгөөний буухиа дэглэмийн үед нийтийн тээврийн хэрэгсэл нь замналын дагуух урьдчилан тогтоосон зогсоолуудад зогсоно.

6 Нийтийн тээврийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

6.1 Нийтийн тээврийн үйлчилгээг техникийн хувьд бүрэн, иж бүрдэлтэй, хөдөлгөөний аюулгүй байдал болон экологийн шаардлагыг хангасан, техникийн хяналтын үзлэгт хамрагдаж тэнцсэн нийтийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

6.2 Улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллага, тээврийн хэрэгсэл болон жолооч нь MNS 5831 “Улс хоорондын автотээврийн ачаа, зорчигч тээвэрлэлт” стандартын шаардлагуудыг хангасан байх ба тээвэрлэлтийн үйл ажиллагаандаа зорчигч тээвэрлэх дүрмийн 3.3.1 болон 3.3.2 дахь заалтуудыг баримтална.

6.3 Орон нутгийн зорчигч тээвэрлэлтийг энэхүү нийтлэг шаардлага болон хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд тавигдах (8-р бүлэг) шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

6.4 Аймгийн төв дэх зорчигч тээвэрлэлтийг энэхүү нийтлэг шаардлага болон хотын доторх ба хот орчмын зорчигч тээвэрлэх (9, 10-р бүлэг) шаардлагад нийцүүлэн



гүйцэтгэнэ.¹

6.5 Захиалгат үйлчилгээг гүйцэтгэх нийтийн тээврийн хэрэгсэл нь тусгай хаягтай байх ба үйлчилгээг Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрмийн 3.8 дахь заалт болон энэхүү стандартаар тавигдах нийтлэг шаардлагын хүрээнд зохион байгуулна.

6.6 Нийтийн тээврийн үйлчилгээнд хурд хэтрүүлэх, хэт удаан явах, багтаамжаас илүү хүн шахаж суулгах, зорчигчийн зааланд гар тээшнээс бусад ачаа тээш тээвэрлэхийг хориглоно.

6.7 Нийтийн тээврийн хэрэгслийн зорчигчийн зааланд 6.7.1, 6.7.2 -д зааснаас хүнд, овортой тээш авч явахыг хориглоно.

6.7.1 Зорчигчийн гар тээш нь 60x30x20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 15 кг-аас хэтрэхгүй жинтэй байна.

6.7.2 Гар тээш нь улс хоорондын зорчигч тээвэрлэлтэд 60x40x20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 30 кг-аас хэтрэхгүй, хот хооронд, орон нутгийн зорчигч тээврийн хэрэгслээр зорчигчийн тээш нь 60x40x20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй, 20 кг-аас хэтрэхгүй жинтэй байна.

6.7.3 Зорчигч нь гар тээшийг нийтийн тээврийн хэрэгсэлд биедээ авч явахыг зөвшөөрнө.

6.7.4 Зорчигчийн 60x40x20 см-ээс илүү овор хэмжээтэй тээшийг нийтийн тээврийн хэрэгслийн тээшний хонгилд эсхүл ачааны тусгай автомашинаар тээвэрлэнэ.

6.7.5 Зориулалтын бус, шаардлага хангаагүй сав, баглаа, боодолтой тээшийг тээвэрлэлтэд хүлээн авахгүй байж болно.

6.8 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, нялх хүүхэдтэй эхчүүд, бага насны хүүхэд, өндөр настан зэрэг хүмүүсийг нийтийн тээврийн хэрэгсэлд орох ба буух, суух, зорчих үед нь жолооч, кондуктор, шалгагч бусад зорчин явагчид анхаарал хандуулж, туслалцаа үзүүлнэ.

6.9 Нийтийн тээврийн хэрэгсэл дотор чиглэл, замналын зураглал, үйлчилгээтэй холбоотой санал гомдол, мэдээлэл өгөх утасны дугаар, цахим хаяг, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой санамжууд, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг, заалт, бусад санамжийг зохих стандартын дагуу байрлуулсан байна.

6.10 Тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгсэлд учирсан техникийн эвдрэл, гэмтлийн талаар холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, саатлыг арилгах, техникийн түргэн тусламж авах, эвдрэлийг арилгуулах, зорчигчийг шилжүүлэн суулгах яаралтай арга хэмжээ авна.

6.11 Осол, аюулын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, холбогдох байгууллага, хүмүүст яаралтай мэдэгдэх, өртөгсдөд анхны тусламж үзүүлэх, аврах, шаардлагатай арга хэмжээ авах шуурхай арга хэмжээний бүдүүвчтэй байна.

6.12 Тээвэрлэгч нь үйлчлэх чиглэлийн эцсийн болон дундын зогсоолд, хөдөлгөөний цагийн хуваарь, тээвэрлэлтийн зай, хоногт гүйцэтгэх рейсийн тоо зэрэг замналын үзүүлэлтүүдийг төлөвлөж баталгаажуулсан байна. Үйлчилгээний үнэ, хөлсний талаар нийтийн зорчигч тээврийн зохицуулах эрх бүхий байгууллагатай зөвшилцөж гэрээнд тусгасан байна.

6.13 Тээвэрлэгч нь үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гарахын өмнө дотор, гадна талыг угаалгаж, зорчигчдын суудал, түшлэг, бариул зэргийг арчиж, бүрэн цэвэрлэгээ хийж, шаардлагатай тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлтийг зохих зааврын дагуу хийнэ.

6.14 Тээвэрлэлтийн явцад зорчигчдыг аюул осолгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрэн хангаж тээвэрлэлтийн замнал, хөдөлгөөний цагийн хуваарийг чанд баримтлан ажиллана.

6.15 Үйлчилгээний явцад замд эвдэрсэн тээврийн хэрэгсэлд техникийн түргэн тусламж үзүүлэх, үйлчилгээний хяналт зохицуулалт хийх, тээвэрлэлтийн мэдээ,

¹ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн С/45 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан



MNS 5012:2021

мэдээлэл өгөх, авах зориулалтын холбоо, мэдээллийн хэрэгслээр хангасан байна.

6.16 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд хөдөлмөрийн, эрүүл ахуйн, техникийн, галын, замын хөдөлгөөний болон экологийн аюулгүй байдлын талаар холбогдох стандартад заасан үзүүлэлт, шаардлагыг хангасан байна.

6.17 Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл бүрийг угаах, цэвэрлэх, арчих хэрэгсэл, материалаар хангасан байна.

6.18 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллагсдыг ажлын хувцас (халат), зураг, нэр бүхий нэрийн хуудастай ажиллуулна.

6.19 Тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд шаардлагатай үед техникийн түргэн тусламж үзүүлэх боломжийг хангаж ажиллана.

6.20 Нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гарах бүрт шалгах механик нь техникийн бүрэн бүтэн байдлыг MNS 4598 стандартын хүрээнд батлагдсан загварын дагуу шалгаж үйлчилгээний даалгаврын хуудас, замын хуудаст тэмдэглэнэ.

6.21 Нийтийн тээврийн хэрэгслийн жолооч, кондуктор, шалгагчийн хөдөлмөр, амралтын горимыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хүрээнд зохион байгуулна.

6.22 Тээврийн хэрэгсэл дотор тээвэрлэлтийн чиглэлийн зураглал, хөдөлгөөний цагийн хуваарь, тамхи татах, ил гал гаргахыг хориглосон тэмдэг бусад санамжуудыг зохих стандартын дагуу бичиж байрлуулсан байна.

6.23 Тээвэрлэгч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэн тусгайлсан тэмдэглэгээ бүхий суудал гаргаж үйлчилнэ.

6.24 Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч нь улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг давхар эрхлэн гүйцэтгэдэг бол хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх байгууллагад тавих нэмэлт шаардлагыг хангасан байна.

7 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагад тавих шаардлага

7.1 Тээвэрлэгч нь нутаг дэвсгэрийнхээ бүртгэх байгууллагад тогтоосон журмын дагуу бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байх бөгөөд эрхлэх ажил, үйлчилгээний нэр, төрөл, үйл ажиллагааг тодорхой заасан байна.

7.2 Ажил үйлчилгээний төрөл, үйл ажиллагаа явуулах хугацааг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн байгуулах гэрээ, дүрэмд тодорхой заасан, тэр нь хүчин төгөлдөр байна.

7.3 Аж ахуйн болон бизнесийн үйл ажиллагааны чиглэл, байршил, хаяг, эрхлэн удирдах, төлөөлсөн эрх бүхий этгээдийн овог нэр өөрчлөгдвөл гэрээ байгуулсан нөгөө талдаа тухай бүр мэдэгдэнэ.

7.4 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх байгууллага нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу тохирлын үнэлгээ үнэлгээ хийлгэж гэрчилгээ авсан байна.

7.5 Тээвэрлэгч нь MNS ISO 45001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо. Шаардлага стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

7.6 Тээвэрлэгч нь MNS 6595:2016 Автотээврийн салбарын ажил мэргэжлийн стандарт. Ерөнхий шаардлагыг хангасан мэргэжлийн ажилтан алба хаагчтай байна.

7.7 Ажилтнуудаа жил бүр эрүүл мэндийн гүнзгийрүүлсэн үзлэгт хамруулах ба жолооч нарыг үйлчилгээнд гаргахын өмнө эмчийн үзлэгт заавал хамруулна.

7.8 Хүний нөөцийн мэдээллийг “Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем”-д заавал бүртгэлжүүлсэн байна.



8 Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх байгууллагад тавих нэмэлт шаардлага

8.1 Хот хоорондын тээвэрлэгч нь MNS 5342 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага стандартын хангасан нийт тээврийн хэрэгслийн 40 хувиас доошгүйг багтаах боломжтой битүү дулаан зогсоолтой байна. Битүү зогсоол нь хувийн, хамтарсан өмчийн, эзэмшлийн байж болох бөгөөд холбогдох баримт бичиг, гэрээгээр баталгаажсан байна.

8.2 Тээвэрлэгч нь MNS 5347 Автомашин угаалгын үйлчилгээ. Ангилал ба ерөнхий шаардлага стандартыг хангасан автомашин угаалгын газартай гэрээ байгуулан тээврийн хэрэгслийн угаалгын үйлчилгээг хийлгэдэг байж болно.

8.3 Тээвэрлэгч нь MNS 5025 –Авто үйлчилгээ. Ангилал ба ерөнхий шаардлага стандартыг хангасан техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын газартай гэрээ байгуулан техникийн засвар үйлчилгээг хийлгэдэг байж болно. Мөн өөрийн эзэмшлийн техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын газартай тохиолдолд авто үйлчилгээний ангиллын гэрчилгээг авсан байна.

8.4 Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэснээс хойш 12-оос дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно.

9 Хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэх байгууллагад тавих нэмэлт шаардлага

9.1 Тээвэрлэгч нь өөрийн эзэмшлийн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын дараах барилга байгууламжтай байна. Үүнд :

9.1.1 Техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын байр.

9.1.2 Тээврийн хэрэгслийн угаалгын цэг.

9.1.3 Дулаан зогсоол.

9.1.4 Ил зогсоол талбай.

9.2 Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний байр, дулаан гаражийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмж нь Барилгын норм ба дүрэмд заасан шаардлагуудыг хангасан, автомашины хөдөлгүүрийн ажилласан хийг зайлуулах, мөн агааржуулах гэрэлтүүлэх, дулаалцуулах систем, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.

9.3 20 хүртэлх автобусанд техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын тоноглогсон суваг эсвэл өргүүр нэг байна.

9.4 Нийтийн тээврийн хэрэгслийн техникийн оношилгоо, үйлчилгээ, засварын байр, дулаан гарааш, угаалгын цэг нь доорх нийтлэг шаардлагыг хангана. Үүнд :

9.4.1 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагууд нийтийн тээврийн хэрэгслийн гадна талыг цэвэрлэх автомат угаалгын цэг ашиглана. Уг цэг нь усыг цэвэршүүлэх, дахин ашиглах нөхцөлийг хангасан байна. (Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө)

9.4.2 Бие засах газар, технологийн болон хэрэглээний халуун ус, ажилчдын хувцас солих болон амрах байртай байна.

9.4.3 Галын аюулгүйн шаардлагын дагуу галын цэгийг төлөвлөж байгуулсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу цэвэр, бохир усны системд холбосон байна.

9.4.4 Дулаан зогсоол нь нийт тээврийн хэрэгслийг 100 хувь нь багтаах багтаамжтай байх бөгөөд барилгын норм ба дүрэмд заасан шаардлагуудыг хангасан, гэрэлтүүлэг, агааржуулалт дулаалцуулах систем, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.



MNS 5012:2021

9.4.5 Ил зогсоолын зам, талбай нь үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн урсгалыг хангасан цардмал, нийт тээврийн хэрэгслийн 80-аас доошгүй хувь нь зогсох хэмжээтэй байна. Явган хүний хатуу хучилттай замтай байх шаардлагатай.

9.5 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь замналын дагуух тодорхой цэгүүдэд жолооч, кондукторын түр амрах, хооллох байр, бие засах газруудыг “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж. Үндсэн шаардлага” MNS 5537 стандартын дагуу зохион байгуулна.


10 Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд тавих шаардлага

10.1 Нийтийн тээврийн хэрэгсэл нь зорчигчдын ая тухтай, аюул осолгүй зорчих, аялах нөхцөл бүрдсэн, техникийн хувьд бүрэн бүтэн, MNS 4598 "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих шаардлага" стандарт болон MNS 4599 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд стандартуудын шаардлагыг бүрэн хангасан техникийн хяналтын үзлэгт хамрагдаж тэнцсэн байна.

10.2 Нийтийн тээврийн хэрэгслийн хаяг тогтоох зориулалтын суурь дээр замналын нэр, дугаар, эцсийн ба дундын зогсоолуудын нэрийг нийтэд мэдэгдэхээр бичиж болон цахим дэлгэц байрлуулсан, мөн хаалга нь зорчигч орох, гарах тэмдэгтэй байна.

10.3 Нийтийн тээврийн хэрэгсэл нь зориулалтын бүрэн бүтэн суудал, бариул, зорчигчдын заал нь бүрэн ажиллагаа бүхий гэрэлтүүлэх ба дулаацуулах систем, зарлах мэдээллийн хэрэгсэл болон хяналтын камертай байна.

10.4 Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэлд харьяалах аж ахуйн нэгж, байгууллагын таних тэмдэг, ялгах тууз (1-р зураг), аяллын дугаар (2-р зураг)-ыг дор дурдсан загварын дагуу зорчигчдод ил тод харагдах газар бичиж байрлуулна. Үүнд:



Түлхүү үг:

Ялгах туузын хэмжээ:

Үсгийн хэмжээ:

Дэвсгэр өнгө:

Үсгийн өнгө:

Урт 2500 мм, өргөн 250 мм

Өндөр 100 мм, өргөн 50 мм

Шар

Хөх

1-р зураг – Ялгах тууз





Түлхүү үг:

Чиглэлийн хаягийн хэмжээ:

Урт 800 мм, Өргөн 200 мм

Үсгийн өнгө:

Хар

Дэвсгэр өнгө:

Шар

2-р зураг – чиглэлийн дугаар

10.5 Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгсэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэн доорх тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Үүнд:

10.5.1 Хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэнийг орох, гарах боломжтой тавцан, төхөөрөмжтэй байх.

10.5.2 Сонсголын бэрхшээлтэй иргэнд зориулан чиглэлийн болон зогсоолуудын нэр бүхий цахим самбар, дэлгэцтэй байх.

10.5.3 Харааны бэрхшээлтэй иргэнд зориулан автомат зогсоол зарлагч болон чанга яригчтай байх.

10.6 Угсраа болон давхар автобусыг зөвхөн хотын доторх болон хот орчмын зорчигч тээвэрлэлтийн ангиллаар ашиглана. Угсраа болон давхар автобусны хойд талд тээврийн хэрэгслийн оврын хэмжээгээр бусад хөдөлгөөнд оролцогч нарт харагдахаар цацруулагч наалт наасан байна.

10.7 Нийтийн тээврийн бага багтаамжийн автобусанд доор дурдсан нэмэгдэл шаардлагыг тавина. Үүнд:

10.7.1 Харьяалах аж ахуйн нэгж, байгууллагын эмблем (лого), гаражийн дугаар, чиглэлийн нэр, дугаарыг баталсан загварын дагуу зорчигчдод ил тод харагдах газар бичиж байрлуулна.

10.7.2 Бага багтаамжийн автобусны хоёр хажуу талд "Нийтийн тээвэр" гэсэн бичээс бүхий туузыг нийтэд тод харагдахаар бичиж байрлуулна. Үүнд:

Туузын хэмжээ:

Урт 2200 мм, өргөн 180 мм

Үсгийн хэмжээ:

Өндөр 100 мм, өргөн 50 мм

Дэвсгэр өнгө:

Шар

Үсгийн өнгө:

Хөх



MNS 5012:2021

Чиглэлийн хаягийн хэмжээ : Урт 400 мм, өргөн 200мм
Үсгийн өнгө: Хар
Дэвсгэр өнгө : Туслах чиглэлд шар,
Буухиа чиглэлд ногоон

10.8 Орон нутаг, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд үйлдвэрлэснээс хойш 10-аас дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахгүй.²

10.9 Хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн автобус, троллейбусанд харьяалах аж ахуйн нэгж, байгууллагын эмблем (лого), гаражийн дугаар, чиглэлийн нэр, дугаарыг баталсан загварын дагуу зорчигчдод ил тод харагдах газар байрлуулна. Үүнд:

10.9.1 Гаражийн дугаарыг автобусны хоёр хажуу, ар талд болон дээвэр дээр,

10.9.2 Чиглэлийн хаягийг урд, хоёр хажуу талд цахим болон бусад хэлбэрээр байрлуулна.

10.10 Нийтийн тээврийн хэрэгслийн гарааш дугаар, чиглэлийн хаяг, иргэдээс санал, гомдол, мэдээлэл авах зурагт хуудасны загварыг эрх бүхий төрийн байгууллагаас батална.

10.11 Зохицуулалтаар болон нэмэлтээр бусад чиглэлд ажиллах нөхцөлд чиглэлийн түр хаягийг батлагдсан загварын дагуу ашиглах бөгөөд нийтийн тээврийн чиглэлийн түр хаягийн загварыг эрх бүхий төрийн байгууллагаас батална.

10.12 Байгалийн шахсан хий (CNG)-н болон цахилгаан хөдөлгүүртэй нийтийн тээврийн хэрэгсэлд галын аюулаас урьдчилан сэргийлэх зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг байрлуулсан байна.

10.13 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд хотын дотор ажиллах тээврийн хэрэгсэл нь удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна.

10.14 Нийтийн тээврийн хэрэгслийн чиглэлийн хаяг нь эрх бүхий төрийн байгууллагаас баталсан загварын дагуу цахим дэлгэц бүхий удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системтэй уялдсан байна. (Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөнө)

10.15 Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгсэл нь заалны цонхонд хуулга, тень наах, хөшиг хийхийг хориглох бөгөөд урд талын салхины шилэнд нарны хамгаалалтаас бусад үзэгдэх орчин хязгаарласан нэмэлт хуулга, тень наахыг мөн хориглоно.

11 Нийтийн тээврийн үйлчилгээний хүний нөөцөд тавих шаардлага

11.1 Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын техникийн асуудлыг шууд эрхлэн удирддаг албан тушаалтан нь автотээврийн мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдаж үнэмлэх, гэрчилгээ авсан байна.

11.2 Нийтийн тээврийн жолооч нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

11.2.1 жолооч нь ерөнхий боловсролын суурь болон бүрэн дунд боловсролтой, автобусны жолооч бэлтгэх сургалтыг дүүргэсэн, жолоочийн мэргэжлийн "Д" ангилалтай, мэргэшсэн жолооч, 21-ээс дээш насны хүн байна. Угсраа болон давхар автобусны жолооч нь дээрх шаардлагыг хангасан жолоочийн мэргэжлийн "Д" ангиллын тээврийн хэрэгслийг 3-аас дээш жил жолоодож дадлагажсан жолооч байна.

11.2.2 нийтийн тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдал, өнгө үзэмж, ариун

- ² Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн С/45 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан.



цэвэр, гэрэлтүүлэх, дулаацуулах систем, шил арчигч, бусад төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцна.

11.2.3 үйлчилгээнд гарахын өмнө тээврийн хэрэгслийг техникийн ерөнхий үзлэг хийж үйлчилгээнд гарах ба үйлчилгээнээс буухдаа тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг шалгах механикчаар шалгуулна.

11.2.4 ажлын шаардлагын үүднээс хөдөлгөөний цагийн хуваарьт өөрчлөлт орсон үед тээвэр зохицуулагч (диспетчер)-ийн хийсэн зохицуулалтыг бүрэн биелүүлнэ. Нийтийн тээврийн удирдлага мэдээлэл болон цахим төлбөрийн системийн ашиглалтын журмыг зөрчих, эвдрэлтэй үед үйлчилгээнд гарахыг хориглоно.

11.2.5 замналын дагуух зогсоолд зогсохдоо “зогсоолын талбай”-н эхэнд зорчигч замын хашлагаас автобусанд суух боломжтой зайд зогсож, зорчигчдыг бүрэн бууж, суусны дараа хаалгаа нээж, хааж, хөдөлгөөний аюулгүй байдал хангагдсаны дараа хөдөлгөөнийг эхлэх, шаардлагатай гэж үзвэл жолооч зорчигчдод хөдөлгөөн эхлэхийг анхааруулна. Автомат зогсоол зарлах төхөөрөмжгүй болон ажиллахгүй байгаа үед жолооч дараагийн зогсоолын нэрийг зарлана.

11.2.6 оройн ээлжид ажилласан жолооч ээлжээс буухдаа шаардлагатай шатахуун, тослох материалыг бүрэн авч, тээврийн хэрэгслийг цэнэглэн зохих гарааш, зогсоолд тавина.

11.2.7 гаражаас гарахдаа байгууллагын тээвэр зохицуулагч (диспетчер)-д жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг шалгуулж, тээврийн даалгаврын хуудсаа авна. Хот хоорондын зорчигч тээвэрлэлтэд шугамын зохицуулалтын тээвэр зохицуулагч (диспетчер)-д рейс тутмын ажлын гүйцэтгэлээ тэмдэглүүлж, төгсгөлд нь хаалгана.

11.2.8 үйлчилгээний үед тээврийн хэрэгсэлд учирсан техникийн эвдрэл, гэмтлийн талаар холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, техникийн түргэн тусламж авах, эвдрэлийг арилгуулах, зорчигчийг шилжүүлэн суулгах яаралтай арга хэмжээ авна.

11.2.9 хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн жолооч нь кондукторгүй ажиллах үед зорчигчийн заалны доторх үйлчилгээ, дэг журам хангуулах ажлыг хариуцна.

11.2.10 нийтийн тээврийн жолооч нь үйлчилгээний явцад доорх үйлдлийг хориглоно. Үүнд:

11.2.10.1. хөдөлгөөний үед жолоочийн бүхээгт хүн суулгах, тамхи татах, гар утсаар ярих, зорчигчдын танхимд дуу хөгжим чанга тавих.

11.2.10.2. хурд хэтрүүлэх, хэт удаан явах, зогсоолын бус газарт хүн буулгах ба суулгах.

11.2.10.3. батлагдсан замналаас хазайж өөр зам, замнал сонгох, хөдөлгөөний цагийн хуваарь зөрчих.

11.2.10.4. хүндэтгэх шалтгаангүйгээр нийтийн тээврийн хэрэгслийг огцом тоормосолж гэнэт зогсоох, хөдлөх зэргээр зорчигчдын тав тухыг алдагдуулах.

11.2.10.5. зайлшгүй шаардлагатай буюу зохих байгууллагын зөвшөөрснөөс бусад хууль бус зураг, зарлал, сурталчилгааны ухуулах хуудас зэргийг нийтийн тээврийн хэрэгсэлд байрлуулах.

11.2.10.6. жолооч нь байгууллагын холбогдох ажилтнуудад зорчигч тээврийн үйлчилгээний шаардлага хангаагүй автобусаар үйлчилгээ явуулах боломжгүйгээ мэдэгдэх үүрэгтэй.

11.2.10.7. үйлчилгээний явцад тээврийн хэрэгслийн тоног төхөөрөмж, эд хогшлыг гэмтээсэн, зорчигчдыг тав тухтай зорчиход саад учруулсан, бусдын эрх чөлөөнд халдаж, танхайрсан, хулгайн хэрэг гарсан зэрэг зөрчлийн үед хөдөлгөөнийг зогсоож, шаардлагатай арга хэмжээ авах.

11.3. Нийтийн тээврийн кондуктор, шалгагч нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

11.3.1. кондуктор, шалгагч нь ерөнхий боловсролын суурь болон бүрэн дунд боловсролтой, 18-аас дээш настай, эрүүл мэндийн шаардлага хангасан, мэргэжлийн



MNS 5012:2021

сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

11.3.2. кондуктор, шалгагч нь соёлч боловсон харьцаатай, зарчимч шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцах зохих мэдлэгтэй, үнэнч шударга ажиллаж, зорчигчдод хөнгөн шуурхай, үйлчилнэ.

11.3.3. кондуктор, шалгагч нь жил бүр эрүүл мэндийн нарийвчилсан үзлэгт орж, шаардлагатай үед эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж байна.

11.3.4. кондуктор, шалгагч нь цэвэр үзэмжтэй хувцаслаж, байгууллагын таних тэмдэг бүхий ажлын хувцас /халат/-тай, өөрийн зураг, нэр бүхий энгэрийн хуудас зүүсэн байна.

11.3.5. ажилд гарахын өмнө нийтийн тээврийн хэрэгслийн цонх, хана, шал, зорчигчийн суудал, түшлэг, бариул зэрэгт чийгтэй цэвэрлэгээ хийж, хог, шороо тоос, тосыг бүрэн цэвэрлэнэ.

11.3.6. кондуктор нь өдрийн орлогын бүрдүүлэлтийг хянаж, байгууллагын санхүүд холбогдох мэдээллийг хүргэж, өдөрт нь тушааж өмчийн зөрчилгүй ажиллана.

11.3.7. зорчигчдоос тогтоосон тарифын дагуу зорчих хөлсийг хурааж авах ба түүнд тохирсон үнэ бүхий тасалбарыг зорчигчийн өмнө урж хүчингүй болгож өгнө.

11.3.8. зорчигчдод ирсэн болон дараагийн зогсоолыг мэдээлнэ. .

11.3.9. кондуктор нь үйлчилгээний явцад доорх үйлдлийг гаргаж болохгүй. Үүнд:

11.3.9.1. зорчигчидтой ширүүн харьцах, элдэв муу үгээр дайрч доромжлох, эрхэнд нь халдах зэрэг соёлгүй байдал гаргах.

11.3.9.2. зураг, овог нэр бүхий үйлчилгээний нэрийн хуудсаа зүүхгүй үйлчлэх.

11.3.9.3. тасалбар өгөхгүйгээр зорчигчдоос мөнгө хурааж авах, тасалбарыг хүчингүй болгохгүйгээр зорчигчдод өгөх.

11.3.9.4. автобусны буудал дээр нийтэд чиглэлийг хашхирч зарлахгүй үйлчилнэ.

11.4. шалгагч, кондуктор нь шаардлагатай тохиолдолд цахим төлбөрийн хэрэгсэл цэнэглэх төхөөрөмж, цахим картын нөөцийг бэлдэж үйлчилгээнд ажиллана.

11.5. шалгагч, кондуктор нь нийтийн тээврээр зорчигчдыг шаардлагатай мэдээллээр хангаж, хөлс төлөлтөд болон үйлчилгээнд биечлэн болон цахимаар хяналт тавин ажиллана.

11.6. Шалгагч нь нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой болон тээврийн хэрэгсэл, жолоочтой холбоотой зөрчил дутагдал, мэдээллийг яаралтай эрх бүхий төрийн байгууллагад мэдэгдэж, арга хэмжээ авна.

11.7. Шалгагч нь нийтийн тээврийн хэрэгслийн дотор болон нийтийн тээврийн зогсоол дээр зорчигчдыг тээврийн хэрэгсэлд суухаас өмнө шалгаж, зөрчилтэй зорчигчийг зорчуулахгүй байх арга хэмжээ авна.

12 Зорчигчдод тавих шаардлага

12.1 Зорчигч нь зорчих тасалбарыг урьдчилан худалдаж авсан байна.

12.2 Зорчигч нь иргэний үнэмлэх, холбогдох бусад баримт бичиг, зорчих тасалбарыг биедээ авч явах, тэдгээрийг жолооч, болон шалгах эрх бүхий хүмүүсийн анхны шаардлагаар шалгуулах.

12.3 Нийтийн тээврийн хэрэгсэлд дарааллыг баримтлан бие биедээ саад болохгүйгээр сууж, буух ба ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэдтэй хүмүүсийг хүндлэн дугаарын эхэнд сууж, буухад тусална.



12.4 Зорчигч нь тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр үйлчлүүлэхээс татгалзах, нийтийн тээврийн тогтоосон чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь баримтлахыг тээвэрлэгчээс шаардах, тээвэрлэлтийн үнэ тариф, замын чиглэл, үйлчилгээний цагийн хуваарь, ачаа хүргэх хугацааны талаар үнэн зөв мэдээлэл авах эрхтэй.

12.5 Улс, хот хооронд, орон нутагт нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь өвчлөх зэрэг хүндэтгэх шалтгаанаар худалдан авсан зорчих тасалбарт заасан чиглэлд зорчиж чадахгүй болсон буюу хүрэх газартаа хүрээгүй буусан тохиолдолд замын үлдсэн хэсэгт ногдох тээврийн хөлсийг тээвэрлэгчээс буцааж авах эрхтэй.

12.6 Нийтийн зорчигч тээвэрлэлтэд биеэ авч явах чадваргүй хүнд өвчтөн, сэтгэл мэдрэлийн өвчтэй, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зөвхөн асран хамгаалагч хүнтэй явахыг зөвшөөрнө.

12.7 Нийтийн тээврийн хэрэгслийн доторх тоноглол, бусад төхөөрөмж, зорчигчийн суудал, түшлэг, бүрээс, бариул зэрэгт өөриймсөг, хайр гамтай хандана.

12.8 Тээврийн хэрэгслийн урд хаалгаар орж, дунд болон хойд хаалгаар бууна.

12.9 Зорчигчид дараах үйлдлийг хориглоно. Үүнд:

12.9.1 хөлс төлөхгүйгээр зорчих

12.9.2 нийтийн тээврийн хэрэгсэлд чанга ярьж хашхирах, бусадтай маргалдах, инээлдэх зэргээр бусдын тайван байдалд нөлөөлөх.

12.9.3 нийтийн тээврийн хэрэгслийн хаалганаас зүүгдэх, хөдөлгөөн эхлэх дохио өгснөөс хойш суух.

12.9.4 нийтийн тээврийн хэрэгслийн эд анги, сандал, түшлэг, бүрээсийг гэмтээх, тамхи татах, хог хаях (самрын яс, тамхины иш, тасалбар), жолоочтой ярьж анхаарлыг нь сарниулах.

12.9.5 өөрийгөө хянах чадваргүй үедээ нийтийн тээврээр зорчих

12.9.6 зориулалтын бус хаалгаар орж гарах, дарааллын журам баримтлахгүй байх

12.9.7 Зорчигчдын амь нас, эрүүл мэнд, эд зүйл болон тээврийн хэрэгсэлд аюул хохирол учруулж болзошгүй химийн болон аюултай бодис, мал, тэжээвэр амьтан, шувуу, амьтны гаралтай түүхий эд авч явахыг зөвшөөрөхгүй.

ТӨГСӨВ.



Ном Зүй

1. Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрэм (Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт)
2. Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт, БД 32-101- 17 (Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 33 дугаар тушаал);
3. Зам, тээвэр барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 153 дугаар зөвлөмж

